



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/207

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Орчны бохирдлыг бууруулах зорилгоор хог тээвэрлэх автомашин худалдан авах зардал (Булган сум)” нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Оттомир” ХХК-тай 116,500,000 (нэг зуун арван зургаан сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Оттомир” ХХК-ийн захирал (Т.Отгонбаяр)-д даалгасугай.

3. Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010277

Булган Аймаг 2026 оны 03 сарын 25 өдөр бүр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 25-ний өдрийн
А/2.01 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоног	А.Гантөмөр
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн А.Гантөмөр
4	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Очирсүрэн

--o00o--